



## САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.06.12

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/
<b>ЗОРИЛГО. САЛБАРЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАН ХУНИЙ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ, АЖИЛЛАХ, СУРАЛЦАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖКРУУЛНА.</b>					
<b>ЗОРИЛТ 1. САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОНО.</b>					
1.1.	Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрхэн хэрэгжүүлж байгааг хяналт шалгалтын дүнд үндэслэн судлан нэгтгэж, боловсронгуй болгох саналыг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 173 дахь заалт)	Хүргүүлсэн тайлан, санал	2023 оны тайлан, санал	2024 оны хяналт шалгалтын дүнд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг гарган, холбогдох саналыг боловсруулж ХҮҮХ-нд хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр 2024 онд хийсэн хяналт шалгалтын дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлыг 11 байгууллагад 89 заалт, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр 9 хуульд 19 заалт, 24 дүрэм, журам, стандартад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж ХҮҮХ-ны даргад 2025.02.21-ний өдрийн 1а/983 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
1.2.	Хяналт шалгалтын объектын эрсдэлийн ангилалд хамаа руулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж саналыг ХҮҮХ-нд хүргүүлнэ.	Шинэчлэн боловсруулсан шалгуур үзүүлэлтийн тоо	Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоолоор батлуулсан 3 хяналтын чиглэлийн 16 төрлийн шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, 2 төрлийн шалгуур үзүүлэлт шинээр боловсруулж, улсын байцаагдаас саналыг авч тусган, танилцуулга, холбогдох мэдээллийг боловсруулж, ХҮҮХ-нд 2025.06.12-ны өдөр 1а/3057 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	Шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж ХҮҮХ-нд хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоолоор батлуулсан 3 хяналтын чиглэлийн 16 төрлийн шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, 2 төрлийн шалгуур үзүүлэлт шинээр боловсруулж, улсын байцаагдаас саналыг авч тусган, танилцуулга, холбогдох мэдээллийг боловсруулж, ХҮҮХ-нд 2025.06.12-ны өдөр 1а/3057 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
1.3.	Хяналтын хуудаст нэмэлт өөрчлөлт оруулж болон шинээр боловсруулж батлуулна.	Шинэчлэн боловсруулсан хяналтын хуудсын тоо	ЭМС-ын 2024 оны А/76 тушаалаар батлуулсан 69 хяналтын хуудас	29 хяналтын хуудаст нэмэлт өөрчлөлт оруулж, 5 хяналтын хуудсыг шинээр боловсруулж батлуулсан байна.	Салбарын зарим хууль тогтоомж, стандартад 2023 онд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 10, эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын чиглэлээр 19, нийт 29 хяналтын хуудаст нэмэлт өөрчлөлт оруулан, эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 1, эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын




					чиглэлээр 5 нийт 6 хяналтын хуудсыг шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн A/26 дугаар тушаалаар батлуулан хяналт шалгалтыг нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийн хурээнд гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлсэн.
1.4.	Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг зохицуулсан журамд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 179 дахь заалт)	ЭМС-ын тушаал	ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаал	Журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	<p>“Эрүүл мэндийн салбарын хяналтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д шинээр 1 хавсралт, 2 зүйл, 12 заалт, шинэчилж найруулсан 32 заалтыг боловсруулж, “Объек тыг хяналт шалгалтад хамруулах давтамжийн хугацаа”, “Улсын байцаагчийн жилийн ажлын хөдөлмөрийн жишиг норматив”, “Нэг объект шалгахад зарцуулах хугацааны норматив”, “Нэг объектын гүйцэтгэлийг шалгахад зарцуулах хугацааны норматив”-т эм эмнэлгийн хэрэгслийн хяналтын чиглэлийг нэмж, боловсролын сургалтын байгууллагад хийх хяналт шалгалтын давтамжийн хугацаанд өөрчлөлт оруулан, “Улсын байцаагчийг чадавхижуулах сургалт зохион байгуулах заавар”-т сургалтын төрлийг нэмж, хэрэгцээний судалгаанд үндэслэн давтан сургалтыг хийх, “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед улсын байцаагчийн ажиллах заавар”-ыг шинээр боловсруулж ЭМС-ын 2025 оны 05 сарын 01-ний өдрийн A/168 дугаар тушаалаар батлуулж, АНЭМГ, ЭЭХХЗГ-т албан бичгээр хүргүүлсэн. 2025.06.09-ний өдөр СХГ, аймаг, нийслэлийн байцаагч наарт цахимаар батлуулсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан.</p>
1.5.	Эрүүл ахуйн тухай, Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 51 дэх заалт)	Үнэлгээний тайлан	-	Үнэлгээний тайлан	<p>Эрүүл ахуйн тухай хуулийн үр дагаврын үнэлгээ хийх ажлын хэсэгт орж ажиллан “Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” боловсруулж, ТНБД-аар батлуулсан. -Хуулийн хэрэгжилт гаргах асуумжийг боловсруулж, 4 жилийн хэрэгжилтийг гаргаж байна.</p>



1.6.	Өргөдөл, гомдолын шийдвэрлэл тийн тайланг Засгийн газарт хүргүүлнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний <b>138</b> дахь заалт) 2025.05.20-оос хойш	Засгийн газарт хүргүүлсэн тайлан	-	Засгийн газарт тайланг улирал тутам хүргүүлсэн байна.	Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн болон эрүүл мэндийн салбарын хэмжээнд утсаар, бичгээр, мэйлээр, цахимаар ирүүлсэн 2025 оны 1-р улирлын өргөдөл гомдолын тайланг нэгтгэн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 05 дугаар сард 2/2814 тоот албан бичгээр хүргүүлсэн.
------	--	----------------------------------	---	---	---

**ЗОРИЛТ 2. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ 2024 ОНЫ 02 ДУГААР ТОГТООЛООР БАТАЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГХЭРЭГЖҮҮЛНЭ.**


2.1	Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн <b>1621</b> объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулна. (Салбарын хяналтын газраас Өмнөговь-10, Дорнод-10, Өвөрхангай-33, Увс-20, УБ 9, нийт 82 объект) (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний <b>18, 32, 175</b> дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналтын чиглэл бүрээр шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга 4	Хяналтын чиглэл бүрээр шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	XYYX-ны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/496 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 1621 объектоос 1108 объектыг хамруулж, 68.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Шалгалтад хамрагдсан объектын 159 буюу 14.3 хувь нь их, 549 буюу 49.5 хувь нь дунд, 400 буюу 36.1 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Хяналт шалгалтын явцад нийт 7865 дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулснаас 9.9 хувь шаардлага хангахгүй дүнтэй гарсан байна. Шалгалтын явцад давхардсан тоогоор 20768 зөрчил дутагдал илэрч, 7516 буюу 36.2 хувийг арилгуулсан, 1354 байгууллагад 14906 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, эхний хагас жилийн байдлаар биелэлт 29.6 хувьтай байна. Хяналт шалгалтын явцад 2577 улсын байцаагчийн дүгнэлт, 327 заалттай 59 зөвлөмж, 340 заалттай 135 эрх бүхий албан тушаалтны албан даалгавар гаргаснаас хэрэгжилт 74.1 хувьтай байна. Шалгалтын явцад 261 байгууллагад 380.550.000 (гурван зуун наян мянга таван зуун тавин) мянган төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж, биелэлт 78.3 хувьтай, 2 байгууллагад 947.000 (есөн зуун дөчин долоон) мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, биелэлт 100 хувь, 9 газрын үйл ажиллагааг түр, 7 газрыг бүр зогсоосон, 23 зөрчлийн хэрэг нээж, 239 хэргийг хялбаршуулсан байдлаар шийдвэрлэсэн
		Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр	УЗХ-ын шийдвэр 1	УЗХ-ын шийдвэр 4	




					байна. Өмнөговь аймагт хийсэн хяналт шалгалтын дүнг 2025.04.24, Увс аймагт хийсэн шалгалтын дүнг 2025.05.01-ний өдөр УЗХ-аар тус тус хэлэлцүүлж, 13 заалт бүхий шийдвэр гаргуулан холбогдох газруудад хүргүүлсэн. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.2	Үндны усны чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 48, 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийслэл, аймаг, сумдын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 43 үүний худаг, 25 насос станц, 23 зөөврийн ус түгээх байр, 98 шугамаар ус түгээх байр, ус хангамжийн төвлөрсөн сүлжээний 101 хэрэглэгч, төвлөрсөн бус ус хангамжийн 80 худаг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний 14 худаг, төвлөрсөн бус ус хангамжтай 79 хэрэглэгч, ус зөөврийн машин 2, гадаргын ус 3 нийт 468 объектыг хамруулан 1054 усны дээж авч, ХАБҮЛЛ, Стандарт, хэмжилзүйн газрын аймаг, нийслэлийн лабораторид нян судлал, хими, хүнд металлын үзүүлэлтээр шинжлүүлсэнээс 6% нь нянгийн тоо үзүүлэлтээр, 9.4% нь магни, 5.6% нь хар тугалга үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй байна. Хяналт шалгалтын явцад нийт 85 зөрчил илрүүлж, 40 заалттай 5 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 1 аж ахуйн нэгжид 2 сая.төгрөгийн тогрууль ногдуулж, унд ахуйн усны чанар, аюулгүй байдалд хийсэн шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 108 дүгнэлт гаргаж хүргүүлсэн байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.3	Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, бохир ус цэвэрлэгээний түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, бохир ус цэвэрлэгээний түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10-00/07 дугаартай удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотын Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй "Хаягдал усны бохирдлыг бууруулахад нөлөөлж буй арьс шир




					боловсруулах, ноос ноолуур угаах, боловсруулах, өлөн боловсруулах, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, талх чихэр, архи ундааны үйлдвэрээс урьдчилсан цэвэрлэх байгууламж сууринуулаагүй болон хаягдал бохир усны чанар, урьдчилсан цэвэрлэх байгууламжтай зэрэг иргэн, аж ахуйн нэгжийн 30 үйлдвэр хяналт шалгалтад хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар Витсамо ХХК, Батбайгаль ХХК, Max экспорт ХХК, Транс трейд ХХК, Стимо ХХК, Хатант интэрнэшнл ХХК, Голдон кофе ХХК, Мөнх-Од трейд ХХК, Агро нэгтгэл трейд ХХК, иргэн Б.Нэргүй, 9 аж ахуйн нэгж, 1 иргэнд улсын /ахлах/ байцаагчын 42 заалт бүхий 10 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.4	Хот, суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 130, 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Хот, суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10-00/08 дугаартай удирдамжийн хүрээнд 5 аймгийн төвийн суурьшлын бүсийн хөрсний 26 цэгээс 26 хөрсний дээж авч, аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораторид шинжлүүлэн, бохирдлын түвшинд үнэлгээ дүгнэлт өгөхөд шинжлэгдсэн дээжийн 14 буюу 53.85% нь цэвэр, 3 буюу 11.54% нь бага бохирдолтой, 2 буюу 7.69% нь дунд зэргийн бохирдолтой, 7 буюу 26.92% нь их бохирдолтой байна. Шинжлэгдсэн дээжийн 3.8%-д <i>Salmonella</i> илэрсэн байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.5	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Нийслэлийн ногоон бүсийн хүүхдийн зуслангийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг нийслэлийн БЗД, СБД, СХД-ийн 6 хүүхдийн зусланг хамруулан хяналт шалгалт хийсэн. Шалгалтын явцад унд ахуйн хэрэгцээний уснаас 5 дээж авч шинжлүүлэхээр лабораторт хүргүүлсэн.




					NЭМГ, НХХААГ, ХБХСГ-аас хамтран хүүхдийн зуслангийн бэлтгэл ажил, эрүүл ахуйн нөхцөл, хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, анхаарах асуудал, халдварт өвчнөөс сэргийлэх, мөн Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага UCS 1204B:2025 стандартыг танилцуулах сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Монголын Үндэсний Зуслангуудын холбоо, хүүхдийн зуслангуудын удирдлага, эмч наарт зохион байгуулсан. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.6	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, улирлын чанартай ажил, үйлчилгээ, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт хийх /Цагаан сар, Хүүхдийн баяр, Наадам, Шинэ жил, бусад/ (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	-Хяналт шалгалтыг ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын ерөнхий байцаагч нарын хамтарсан удирдамжийн хүрээнд давхардсан тоогоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 3237 объектод хяналт шалгалт хийж, 2455 зөрчил дутагдлыг илрүүлж, 39 ААН, иргэнд 240 заалттай улсын байцаагчийн зөвлөмж, 51 ААН, иргэнд дутагдлыг арилгуулахаар 296 заалттай албан шаардлагыг хүргүүлж, 175 заалт буюу 59.1%-ийг хангуулж, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийг зөрчсөн 40 аж ахуй нэгж, иргэнд 34,200,000 (гучин дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөгийн шийтгэврийг хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн ногдуулж, 100 хувь барагдуулан, зөрчлийн үр дагаврыг арилгуулахаар эрх бүхий албан тушаалтын 29 заалттай 18 албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Шошгын зөрчилтэй 354 ширхэг, 18 кг, 2,378,000 (хоёр сая гурван зуун далан найман мянган) төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг буцаан татаан авалт хийлгэж, хадгалалтын хугацаа хэтэрсэн 3022 ширхэг, 68 кг, 7.057.000 (долоон сая тавин долоон мянган) төгрөгийн бүтээгдэхүүнийг албадлагын журмаар хураан авч, холбогдох орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн. 2024-2025 оны шинэ жил, 2025 оны цагаан сарын баяр угtsан хяналт шалгалтын дүнгийн



					танилцуулгыг нэгтгэн, ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газарт 9/1436 дугаартай албан бичгээр болон цахимаар хүргүүлсэн. -Эх үрсийн баярын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнгийн танилцуулгыг аймаг, нийслэлийн ЭМГ-ас хүлээн авч байна. Хяналт шалгалтын нэгтгэл танилцуулах хугацаа болоогүй.
2.7	Нялх, балчир хүүхдийн хүнс импортлогч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	-Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/17 дугаартай удирдамжийн хүрээнд 19(55.8%) объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Шалгалтад хамрагдсан объектыг 10.13.3 кодтой "Хүнсний агуулахын эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах" хяналтын хуудсаар үнэлэхэд 12 ( 63%) нь дунд, 7 (37%) бага эрсдэлтэй үнэлэгдэн, 70 зөрчил, дутагдал илрүүлж, 4 ААН-д 6 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.8	Эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусlamж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусlamж үйлчилгээнд хийх урьдчилан сэргийлэх хяналтад 84 эмнэлэг хамрагдсан. Шалгалтын явцад 668 зөрчил илрүүлж, 248 (37%)-ыг газар дээр нь арилгуулан, 54 эмнэлэгт 652 заалттай албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, 6 байгууллага, албан тушаалтанд хялбаршуулсан журмаар 7500000 (долоон сая таван зуун мянган) төгрөгийн шийтгэвэр оногдуулж барагдуулсан байна. Хяналт шалгалтыг лабораторийн шинжилгээтэй хийж, үйл ажиллагааны 16, бүтээгдэхүүний 3, ажлын байрны 3 нийт 22 дүгнэлт гаргасан. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.9	Хүүхэд, өсвөр үеийн кабинетийн үзүүлж буй тусlamж үйлчилгээнд хийх урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Хүүхэд, өсвөр үеийн кабинетийн үзүүлж буй тусlamж үйлчилгээнд хийх урьдчилан сэргийлэх шалгалтад нийт 36 эмнэлэг (хагас жилд 24) хамруулахаар төлөвлөж, 100 хувьтай буюу 27 эмнэлэгт урьдчилан сэргийлэх




	төлөвлөгөөний 176 дахь заалт)				шалгалт хийгдсэн. Эмнэлгүүдэд нийт 215 зөрчил илэрч 23 хувь (49)-ийг арилгуулан, 20 эмнэлэгт 183 заалттай албан шаардлага өгсөн байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.
2.10	Эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдвартгуйжүүлэлтийн бодисын үйлдвэр, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, эмнэлгийн багаж, материалын ариутгалын үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	СХГ-ын даргын баталсан “Эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдвартгуйжүүлэлтийн бодисын үйлдвэр, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, эмнэлгийн багаж, материалын ариутгалын үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт хийх тухай” 10-00/10 дугаартай удирдамжийн хүрээнд Эм эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 38 байгууллагын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт хийж, дотоод орчны агаараас 11, арчдас 55, халдвартгуйжүүлэх бодисын 4, ариун материалын 29 дээж авч, СХЗХ-ийн лабораториид шинжлүүлэхэд арчдасны 3.6%-д нянгийн бохирдол илэрсэн. Шалгалтын явцад нийт 269 зөрчил илрүүлэн, 25 байгууллагад 190 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, 7 байгууллагад гүйцэтгэлийн хяналт хийхэд албан шаардлагын хэрэгжилт 59.4%-тай байна.
2.11	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 <sup>2</sup> .1-д зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус шалгалт хийнэ.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	-	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу 1730 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдэж, хугацаанд нь шийдвэрлэсэн. Шалгалтын явцад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар улсын байцаагчийн 64 заалт бүхий 18 албан шаардлага үйлдэж, холбогдох газруудад нь хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэнд хяналт тавьж ажилласан. Зөрчил гаргасан нийт 28 байгууллага, аж ахуйн нэгжид 30.5 сая төгрөгийн тorgууль шийтгэвэр ногдуулж, 67.2 хувийг нь барагдуулсан. Салбарын хяналтын газраас иргэний өргөдөл, гомдоор 25, удирдах дээд байгууллагын шийдвэрээр 7 объектод хяналт шалгалт хийж, 28.0 хувьд нь гүйцэтгэлийн хяналт шалгалт




					хийсэн байна.
2.12	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.	Сургалтын тайлан	2024 онд хяналт шалгалтад хамрагдсан 2220 аж ахуйн нэгж байгууллагад сургалт зохион байгуулсан	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын 50-иас доошгүй хувийг хамруулан сургалт зохион байгуулсан байна.	Эхний хагас жилд төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан байгууллагын 60 хувьд нь нийт 4781 албан тушаалтанд хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга зам болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар байгууллагын сургалт хийж ажилласан байна. СХГ-аас Дорнод,Өмнөговь, Увс,Өвөрхангай аймагт төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн байгууллагуудыг 100 хувь хамруулж, нийт 782 холбогдох албан тушаалтанд дотоод хяналтыг төлөвшүүлэх, тогтмолжуулах чиглэлээр сургалт мэдээлэл хийж ажилласан.

**ЗОРИЛТ 3. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.**


3.1	Эрүүл ахуйн тухай хуулийн 5.3 Барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл ахуйн дүгнэлт гаргана. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Улсын хэмжээний нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Улсын хэмжээнд шинээр барих болон өргөтгөх барилга байгууламжийн нийт 662 зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийж, улсын байцаагчийн дүгнэлт гаргаж баталгаажуулсан. Барилга байгууламжийг шинээр ашиглалтад оруулах комиссын 79 удаагийн үйл ажиллагаанд эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын байцаагчид оролцож, 79 барилгыг ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн. Ажлын зураг төслийг зөвшилцөхгүйгээр барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн, зураг төсөл нь эрүүл ахуйн норм, стандартын шаардлага хангаагүй 21 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 47.250.0 (дөчин долоон сая хоёр зуун тавин) мянган төгрөгийн тортготийн хэмжээ авсан. Хяналт шалгалт үргэлжилж байна.
3.2	Эрүүл ахуйн тухай хуулийн 8.2 Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй, өндөр эрсдэлтэй мал, амьтны гаралтайгаас бусад түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлоход эрүүл ахуйн	Хүсэлтийн шийдвэрлэлт	100%	100%	Эрүүл ахуйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу цусны ийлдэс, цусны сийвэн, шээсний сорьцыг АНУ, БНСУ, ХБНГУ, Хонконг улс руу илгээх 64 хүсэлтийн дагуу хяналт хийж 64 дүгнэлт гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн.



	дүгнэлт гаргана. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)				
3.3	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5 Нялх, балчир, бага насы болон цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад зориулсан хоол үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Нялх, балчир, бага насы болон цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад зориулсан хоол үйлдвэрлэлийг шинээр эрхлэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 10-00/14 дугаар бүхий удирдамжийг боловсруулж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт цахимаар хүргүүлсэн. Хяналт шалгалтыг нийт 24 сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн газруудад хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтын явцад 10.12.1 кодтой “Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нэхцэл шаардлагыг шалгах” хяналтын хуудсаар үнэлэхэд 15 буюу 62.5 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, улсын (ахлах) байцаагчийн дүгнэлт үйлдсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 12 заалттай 2 албан үйлдэж, холбогдох газруудад нь хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.
3.4	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5 Өндөр эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж дүгнэлт гаргана. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Аж ахуйн нэгж, иргэнээс өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд дүгнэлт гаргуулах 23 (нийслэлд 14, аймагт 9) хүсэлтийг хүлээн авч, хуульд заасан хугацааны дотор 100% шийдвэрлэсэн. Хяналт шалгалтаар үйлдвэрийн эрүүл ахуйн бусийн хэмжээ хангагүй 2 ААН-ийн хүсэлтийг буцааж, 21 үйлдвэрийг 10.11.1 кодтой “Нялх, балчир хүүхдийн хүнс үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нэхцэл шаардлагыг шалгах хяналтын хуудас”, 10.11.2 кодтой “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэхэд урьдчилсан хяналт хийж эрүүл ахуйн хяналтын хуудас”, 10.11.15 кодтой “Max, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нэхцэл шаардлагыг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд 4 (19%) нь “их эрсдэлтэй”, 8 (38%) “дунд эрсдэлтэй”, 9 (42.8%) нь “бага эрсдэлтэй” үнэлэгдсэн.



					Baga эрсдэлтэй үнэлэгдсэн 9 (сүү боловсруулах- 1, мах боловсруулах-7, балчир хүүхдийн хүнс үйлдвэрлэгч-1) ААН, иргэнд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Max, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт", Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт MNTR 2:2011-ийн эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа тухай улсын байцаагчийн 9 дүгнэлт үйлдэж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтын биелэлтийг ханггуулж ажилласан. Хяналт шалгалт үргэлжилж байна.
3.5	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 23 дугаар зүйл Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр хамгаалуулагчийн хоол хүнсний аюулгүй байдалд хөндлөнгийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Төрийн тусгай хамгаалалтын газраас ирүүлсэн 25 албан бичгийг үндэслэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх заалтын хүрээнд хөтөлбөрт тусгагдсан нэр бүхий 78 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, ирүүлсэн албан хүсэлтийг 100% шийдвэрлэсэн. Хяналт шалгалтаар эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангагүй 54 дутагдал илрүүлж, арилгуулах арга хэмжээг яаралтай авсаны дунд болзошгүй эрсдэлээс сэргийлэн, хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангулан ажилласан.
3.6	Тамхины хяналтын тухай хууль 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.10.3, 7.11.3 Тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох, эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаарх болон тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж дүгнэлт	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	-Тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодисын агууламж, чанар, аюулгүй байдалд дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлсэн давхардсан тоогоор 14 аж ахуйн нэгжийн хүсэлтээр 15 нэр төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнд Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журамд заасны дагуу дагалдах бичиг баримтад эрсдэлийн үнэлгээ хийж, бүтээгдэхүүний Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагaa лабораторид шинжлүүлэн, дүнг үндэслэн стандартын шаардлагад нийцсэн тухай улсын ахлах



	гаргана. (ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 176 дахь заалт)				байцаагчийн 8 дүгнэлт үйлдэж, хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн. Хяналт шалгалтын явцад янжуур тамхины загвар дээжийн хайрцаг дээрхи эрүүл мэндийн анхааруулга, шошгын мэдээлэлд илэрсэн дутагдлыг арилгуулахаар 3 ААН-д 10 заалттай албан шаардлагыг хүргүүлэн, хэрэгжилтийг 100% хангулсан. -Батлагдсан удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн ЭМГ-аас тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах үйл ажиллагааны зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацааг сунгуулах 572 худалдааны газарт хяналт хийж, 10.13.2 кодтой хяналтын хуудасны үнэлгээгээр "бага эрсдэлтэй" үнэлэгдсэн 547 газарт "Ажлын байрны тухай" улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Хяналт шалгалтаар "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2024" стандарт хангаагүй давхардсан тоогоор 1074 зөрчил, дутагдлыг илрүүлэн, 49.3%-г богино хугацаанд арилгуулан, 73 заалттай 15 улсын байцаагчийн зөвлөмж, 171 заалттай 17 хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Шалгалтаар 2 ААН, иргэнд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн заалтаар 1.300.000 (нэг сая түрван зуун мянга)төгрөгөөр торгох шийтгэлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Хяналт шалгалт үргэлжилж байна.
3.7	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 <sup>1</sup> .1.3, 15 <sup>2</sup> .1.3 Согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэх зөвшөөрөл шинээр авах, зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж дүгнэлт гаргана.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 оны хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	ЭМЯ, ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн хамтран баталсан удирдамжийн хүрээнд ААН-ээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 1168 объектод төлөвлөгөөт бус хамтарсан хяналт шалгалт хийлээ. 8.10.4 кодтой "Согтууруулах ундаагаар үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг шалгах хяналтын хуудас", 8.11.2 кодтой "Согтууруулах ундаа худалдаа худалдааны газрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-ны үнэлгээгээр "бага эрсдэлтэй" үнэлгээтэй 996 ААН-д холбогдох стандартыг хангасан тухай улсын(ахлах) байцаагчийн дүгнэлт гаргасан.


3.5  
methyl  
succinate  
3.5  
methyl  
succinate

3.5  
methyl  
succinate

	(ЭМЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний <b>176</b> дахь заалт)				Xяналт шалгалтын явцад хяналтын хуудасны асуумжаар шаардлага хангаагүй 1125 дутагдал илрүүлэн, 37 аж ахуйн нэгжид 276 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлж, 61.2%-г арилгуулсан байна. Сэлэнгэ аймгийн Эруул мэндийн газрын Хяналтын нэгжээс Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийг үндэслэн 2 аж ахуйн нэгжид нийт 4.000.000(дөрвөн сая) төгрөгийн тorgуулийг хялбаршуулсан журмаар ногдуулж, 75%-г барагдуулаад (хугацаа болоогүй 25%)байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.
--	--	--	--	--	---

**ЗОРИЛТ 4. ОРОН НУТАГ ДАХЬ УЛСЫН /АХЛАХ/ БАЙЦААГЧДЫГ БОДЛОГО, УДИРДЛАГА, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙ, ЗЭВЛӨМЖӨӨР ХАНГАНА.**

4.1.	ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаалын 6 дугаар хавсралтын 2.1 Шинэ байцаагчдад баримжаа олгох сургалт зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалтын тоо	-	Эрх олгосноос хойш ажлын 10 хоногийн дотор сургалт зохион байгуулсан байна.	-Улсын байцаагчдын судалгааг шинэчилж нийт 102 улсын байцаагчаас авч нэгтгэсэн. -Улсын байцаагчдын сургалтын хэрэгцээний судалгаа хийх аргачлал" боловсруулж батлуулсан. -Салбарын хяналтын газар болон НЭМГ, 21 аймгийн ЭМГ-ын нийт улсын байцаагчдаас аргачлалын дагуу судалгаа авч нэгтгэн, 5 хяналтын чиглэлээр сургалтын сэдэв тус бүрээр, зохион байгуулах хугацаа, сургалтын хэлбэр, зохион байгуулах газар, хичээл заах багшийн төрлөөр гаргаж давхардан тоогоор 160 сэдвээр сургалтын хэрэгцээ шаардлага байгааг гарган Салбарын хяналтын газрын улсын ахлах байцаагчдад хүргүүлсэн. -Журамд заасны дагуу Шинэ байцаагчид баримжаа олгох сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулан, хичээлүүдийг ррт хэлбэрээр бэлтгэж тайлант хугацаа буюу 2025.01.02-2025.06.09-ний хооронд 2 удаа 11 газрын 20 улсын байцаагчид сургалтыг цахимаар зохион байгуулсан.
4.2	ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаалын 6 дугаар хавсралтын 2.1.1 Орон нутаг дахь улсын	Сургалтын хэрэгцээний үнэлгээ	-	Сургалтын хэрэгцээний үнэлгээ хийсэн байна.	-НЭМГ, 21 аймгийн ЭМГ-ын нийт улсын байцаагч наарт 2025 оны 02 дугаар сард цахимаар 2025 оны зөвлөмж, төлөвлөлт, төлөвлөгөөт хяналт шалгалт, урьдчилан



	байцаагчдыг чадавхижуулах давтан сургалтыг зохион байгуулна.	Сургалтын тайлан		Сургалт зохион байгуулсан нэгдсэн тайлан гаргасан байна.	сэргийлэх, хяналтын хуудасны шинэчлэл, цаашид анхаарах асуудлаар сургалт зохион байгуулсан. -Өмнөговь, Увс, Дорнод, Өвөрхангай аймагт хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад тус аймгуудын ЭМГ-ын хяналтын чиглэлийн улсын байцаагч наарт(17) ажлын байрны чадавхижуулах сургалт хийсэн. -Эмчилгээний чанаарын хяналтын улсын байцаагчийн сургалтын хэрэгцээний судалгаан дээр үндэслэн эмчилгээний чанаарын хяналтын улсын байцаагч наарт "Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж" сэдэвт сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 15.00-17.30 цагийн хооронд баталсан хөтөлбөрийн дагуу цахим сургалтыг зохион байгуулж, эмчилгээний чанаарын хяналтын улсын 22 байцаагчид хамруулсан. Хөтөлбөрийн дагуу Манас таталтын урьдал үеийн оношилгоо, эмчилгээний зарчим, хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж авах арга хэмжээ зэрэг сэдвийн хүрээнд хийгдэж, улсын байцаагч нарын мэдлэг нэмж, мэдээлэл өгсөн ач холбогдолтой сургалт болсон.
4.3	Улсын байцаагчдад зориулсан хяналт шалгалтын эрх зүйн баримт бичгийг эмхэтгэж гарын авлага гаргана.	Гарын авлага	-	Гарын авлага гаргаж улсын байцаагчдад хүргүүлсэн байна.	Улсын байцаагчдад зориулан Засгийн газрын 6 тогтоолоор батлагдсан 5 журам, Сайдын 6 тушаалаар батлагдсан 10 журам, нийт 15 эрх зүйн баримт бичгийг эмхэтгэн, 60ш хэвлүүлж, шинээр эрх авсан улсын байцаагчдад хүргэж, баримжкаа олгох гарын авлага болох ач холбогдолтой болсон.

---Оо---

ХЯНАСАН: САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

НЭГТГЭЖ БОЛОВСРУУЛСАН: УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, АХЛАХ ШИНЖЭЭЧ


О.ЭНХБОЛД

Л.ГЭРЭЛМАА




**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ/САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗАР 2025.06.18**


Төлөв лөгөөний заалт	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтолт түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах үндсэн нэгж	Хамтран хэрэгжүүлэх нэгж	Биелэлт
18	ЗГУАХ 2.2.1.15.337 Орон нутгийн онцлогт тохирсон хүнс хангамжийн сүлжээ бий болгоно.	Сургалтад хамрагдсан хоол зүйчдийн тоо	/-/	Хоол зүйчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.	I-IV улирал	НЭМБГ	СХГ	Тайлангийн хугацаанд Увс, Өмнөговь, Өвөрхангай, Дорнод амьтагт хийсэн хамтарсан хяналт шалгалтад хамрагдсан сургалтын боловсролын байгууллага, 21 аймаг, нийслэлд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан объектуудын ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, хоол зүйч, эмч, тогооч наарт хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зохион байгуулалт, хяналтын чиглэлээр илэрсэн зэрчил дутагдалд үндэслэн арилгах, цаашид давтан гаргахгүй байх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын байрны сургалт зохион байгуулсан.
		Шим тэжээлийн тооцоолол хийлгэсэн сургуулийн тоо	/-/	Сургуулийн хоолны шим тэжээлийн найрлагыг тооцоолж, чанарыг сайхруулсан байна.				
32	Хог хаягдлын тухай хууль 8.3.2. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тэзвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам, аргачлал, зааврыг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.	Эрүүл мэндийн сайдын тушаал	/-/	Журам, заавар, аргачлалыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.	III-IV улирал	НЭМБГ	СХГ	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/193 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг зохицуулах заавар", 2025 оны 05 дугаар сарын 01-ний А/173 дугаар "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, тэзвэрлэх, дахин боловсруулах, устгах заавар шинэчлэн батлах тухай" тушаалыг тус тус батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Хэрэгжилтийг жилийн эцсээр тайлагнана.
48	ЗГУАХ 2.3.1.2.393 Эрүүл мэндэд эрдэл үүсгэгч хүчин зүйлийг бууруулж хүний амьдрах, ажиллах эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.	"Орчны эрүүл мэнд" арга хэмжээний хэрэгжилтийн хувь	/-/	30	I-IV улирал	НЭМБГ	СХГ	ЭМСайдын А/166 дугаар тушаалаар байгуулагдсан Орчны эрүүл мэнд 2025-2028 арга хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн 3 удаагийн хуралд 2 удаа оролцож, төлөвлөгөөний төсөлд ус хангамж, ариун цэвэр, хөрсний бохирдолтой холбоотой үйл ажиллагааг тусгуссан. Эхний байдлаар боловсруулсан төлөвлөгөөний төслийг 3-р улиралд өргөтгөсөн хэлэлцүүлэгт танилцуулж санал авахаар төлөвлөж байна.
51	Дархлаажуулалтын тухай, Эрүүл ахуйн тухай, Хүний дархлан хомсдлын вирусын халдвар, дархланы олдмол хомсдлоос сэрийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийнэ	Хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан	/-/	Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ бүрэн хийгдсэн байна.	I-III улирал	НЭМБГ	СХГ, ТЗУГ-XX	Эрүүл ахуйн тухай хуулийн үр дагаврын үнэлгээ хийх ажлын хэсэгт ажиллан "Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал" боловсруулж, ТНБД-аар баттуулсан. Хуулийн хэрэгжилт гаргах асуумжийг боловсруулж, 4 жилийн хэрэгжилтийг гаргах материалыудыг цуглуулж гаргаж байна.



Төлөв легөө ний заалт	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтолт түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах үндсэн нэгж	Хамтран хэрэгжүү лэх нэгж	Биелэлт
130	ЗГУАХ-3.4.3.3.999 Хөрсний няангийн болон хүнд металлын бохирдлын судалгаанд үндэслэн бохирдол ижтэй газруудад бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Тухайн жилийн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Томоохон хот суурин газруудад Хөрсний няангийн болон хүнд металлын бохирдлын судалгааг эхлүүлсэн.	100	I-IV улирал	CХГ		Хот, суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 10-00/08 дугаартай удирдамжийн хүрээнд 5 аймгийн төвийн суурьшлын бүсийн хөрсний 26 цагээс 26 хөрсний дээж авч, аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн лабораториид шинжлүүлэн, бохирдлын түвшинд үнэлгээ дүгнэлт өгөхэд шинжлэгдсэн дээжийн 14 буюу 53.85% нь цэвэр, 3 буюу 11.54% нь бага бохирдолтой, 2 буюу 7.69% нь дунд зэргийн бохирдолтой, 7 буюу 26.92% нь их бохирдолтой байна. Шинжлэгдсэн дээжийн 3.8%-д Salmonella илэрсэн байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.
138	Өргөдөл, шийдвэрлэлтийн гомдлын тайланг Засгийн газарт хүргүүлнэ.	3Г-т хүргүүлсэн тайлан	Тайланг улирал тутам хүргүүлдэг.	Засгийн газарт тайланг улирал тутам хүргүүлсэн байна.	I, II, III, IV улирал	CХГ		Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн болон эрүүл мэндийн салбарын хэмжээнд утсаар, бичгээр, мэйлээр, цахимаар ирүүлсэн 2025 оны 1- р улирлын өргөдөл гомдлын тайланг нэгтгэн Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 05 дугаар сард 2/2814 тоот албан бичгээр хүргүүлсэн.
173	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.3 Хууль тогтоомж, нийтээр дагаж мердхөөр тогтоосон журмыг хэрхэн хэрэгжүүлж байгааг хяналт шалгалтын дунд үндэслэн судлан нэгтгэж, боловсронгуй болгох санаалыг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлнэ.	Хүргүүлсэн тайлан, санал	2023 оны тайлан, санал	2024 оны хяналт шалгалтын дунд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг гарган, холбогдох санаалыг боловсруулж XYX-нд хүргүүлсэн байна.	I улирал	CХГ		Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр 2024 онд хийсэн хяналт шалгалтын дунд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлыг 11 байгууллагад 89 заалт, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр 9 хуульд 19 заалт, 24 дүрэм, журам, стандартад нэмэлт өөрчлөлт оруулах санаалыг боловсруулж, XYX-ны даргад 2025.02.21-ний өдрийн 1а/983 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
174	Хяналт шалгалт хийх нийтлэг журмын 3.13.2 Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт тайланг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлнэ.	Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт тайлан	2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө ний биелэлт тайланг XYX- нд 2024.12.05- ны өдөр хүргүүлсэн.	2025 оны хяналт шалгалтын нэгтгэл тайланг XYX-нд хүргүүлсэн байна.	IV улирал	CХГ		Хугацаа болоогүй, 4-р улиралд хийгдэнэ.



Төлөв легөө ний заалт	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах үндсэн нэгж	Хамтран хэрэгжүү лэх нэгж	Биелэлт
175	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 <sup>1</sup> Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоогоор батлагдсан их, дунд эрсдэлтэй үнэлгэдсэн 1621 объектод, төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	Хяналтын чиглэл бүрээр нэгдсэн танилцуулга -4	Хяналтын чиглэл бүрээр шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гаргасан байна.	I-III улирал	CХГ		XYYX-ны 2024 оны 02 дугаар тогтоогоор батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/496 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 1621 обьектоос 1108 обьектыг хамруулж, 68.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Шалгалтад хамрагдан обьектын 159 буюу 14.3 хувь нь их, 549 буюу 49.5 хувь нь дунд, 400 буюу 36.1 хувь нь бага эрсдэлтэй үнэлгэдсэн. Хяналт шалгалтын явцад нийт 7865 дэж авч лабораторийн шинжилгээнд хамруулсаас 9.9 хувь шаардлага хангахгүй дүнтэй гарсан байна. Шалгалтын явцад давхардсан тоогоор 20768 зөрчил дутагдал илрэ, 7516 буюу 36.2 хувийг арилгуулсан, 1354 байгууллагад 14906 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, эхний хагас жилийн байдааар биелэлт 29.6 хувьтай байна. Хяналт шалгалтын явцад 2577 улсын байцаагчийн дүгнэлт, 327 заалттай 59 зөвлөмж, 340 заалттай 135 эрх бүхий албан тушаалтын албан даалгавар гаргаснаас хэрэгжилт 74.1 хувьтай байна. Шалгалтын явцад 261 байгууллагад 380.550.000 (гурван зуун наян мянга таван зуун тавин) мянган төгрөгийн тортгудуул шийтгэвэр ногдуулж, биелэлт 78.3 хувьтай, 2 байгууллагад 947.000 (есен зуун дөчин долоон ) мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, биелэлт 100 хувь, 9 газрын үйл ажиллагаа түр, 7 газрыг бүр зогсоосон, 23 зөрчлийн хэрэг нээж, 239 хөргийт хялбаршуулсан байдааар шийдвэрлэсэн байна. Өмнөговь аймагт хийсэн хяналт шалгалтын дүнг 2025.04.24, Ува аймагт хийсэн шалгалтын дүнг 2025.05.01-ний өдөр УЗХ-аар тус тус хэлэлцүүлж, 13 заалт бүхий шийдвэр гаргуулан холбогдох газруудад хүргүүлсэн. Хяналт шалгалт үргэлжилж байна.
176	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 <sup>3.1</sup> . Үрьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулна.	17 төрлийн хяналт шалгалт	15 төрлийн хяналт шалгалт	Хяналт шалгалтыг бүрэн гүйцэтгэж, хяналт шалгалтын төрөл бүрээр нэгдсэн танилцуулга гаргасан байна.	I-IV улирал	CХГ		Үрьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрүүл мэндийн байгууллагад 4, орчны чиглэлийн байгууллагад 4, хүнсний чиглэлийн байгууллагад 6, сургалтын байгууллагад 2, нийт 16 чиглэлээр 6047 обьектыг хамруулсан хийж, 6015 зөрчил илрүүлэн, 32 хувийг газар дээр нь арилгуулж, 86 дүгнэлт гарган, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр 99 аж ахуйн нэгж, байгууллагад 1025 заалттай албан шаардлага хүргүүлэн, 73 аж ахуйн нэгж, байгууллагад 96.250.0 (ерэн зургаан сая хоёр зуун тавин) мянган төгрөгийн тортгудуул шийтгэвэр ногдуулж, барагдуулсан байна. Хяналт шалгалт үргэлжилж байна. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2025-2026 оны хичээлийн жилийн бэлтгэл ажилд үрьдчилан сэргийлэх хяналт шалгалт 2025 оны 08-10 сард хийгдэнэ.



Төлөв легөө ний заалт	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтолт түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах үндсэн нэгж	Хамтран хэрэгжүү лэх нэгж	Биелэлт
177	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 <sup>1</sup> .1 Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлж батлуулна.	Батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөө	2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөө	2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.	IV улирал	CХГ		Хугацаа болоогүй 4-р улиралд хийгдэнэ.
178	Хяналт шалгалт хийх нийтлэг журмын 2.8 Улсын хэмжээнд 2026 онд хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг ЭМС-ын 2024 оны A/496 дугаар тушаал	Эрүүл мэндийн сайдын тушаал	2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг ЭМС-ын тушаалаар батлуулсан байна.	2026 онд хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг ЭМС-ын тушаалаар батлуулсан байна.	IV улирал	CХГ		Хугацаа болоогүй 4-р улиралд хийгдэнэ.
179	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.1, ЗГ-ын 2022 оны 479 дүгээр тогтоолын 2 дахь заалт Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын ўйл ажиллагааг зохицуулсан журамд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна.	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМС-ын 2024 оны A/309 дүгээр тушаал	Журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	II-IV улирал	CХГ		Эрүүл мэндийн салбарын хяналтын ўйл ажиллагааг зохицуулах журам"-д шинээр 1 хавсралт, 2 зүйл, 12 заалт, шинэчилж найруулсан 32 заалтыг боловсруулж, "Объект тиг хяналт шалгалтад хамруулах давтамжийн хугацаа", "Улсын байцаагчийн жилийн ажлын хөдөлмөрийн жишиг норматив", "Нэг объект шалгахад зарцуулах хугацааны норматив", "Нэг объектын гүйцэтгэлийг шалгахад зарцуулах хугацааны норматив"-т эм эмнэлгийн хэрэгслийн хяналтын чиглэлийг нэмж, боловсролын сургалтын байгууллагад хийх хяналт шалгалтын давтамжийн хугацаанд өөрчлөлт оруулан, "Улсын байцаагчийг чадавхижуулах сургалт зохион байгуулахаа заавар"-т сургалтын төрлийг нэмж, хэрэгцээний судалгаанд үндэслэн давтан сургалтыг хийх, "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед улсын байцаагчийн ажиллах заавар"-ыг шинээр боловсруулж, ЭМС-ын 2025 оны 05 сарын 01-ний өдрийн A/168 дугаар тушаалаар батлуулж, АНЭМГ, ЭЭХХЗГ-т албан бичгээр хүргүүлсэн. 2025.06.09-ний өдөр СХГ, аймаг, нийслэлийн байцаагч нарт цахимаар батлуулсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан.

ХЯНАСАН: САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН: УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, АХЛАХ ШИНЖЭЭЧ

О.ЭНХБОЛД

Л.ГЭРЭЛМАА

07/06/19

